



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/433

Мандалговь

Г Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай Г

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн конторын барилгын засварын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнхжаргал	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Гишүүд:	А.Бямбаа Э.Энхмэнд	("Мандал харш" ХХК-ийн инженер) (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Л.Эрдэнэбуд	("Баянгийн говь" ХХК-ийн ерөнхий захирал)
	М.Хүүбаян	(Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал эмнэлгийн албаны дарга)
	П.Алтанчимэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)

Хоёр. Засварын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010476